



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 0213

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн бодлогыг таниулах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, ойлголт мэдээллийг нэгтгэх, шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0561